

## ОРХОН АЙМГИЙН ИТХ-ЫН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ САЙЖРАХ ОВОГТОЙ ЦЭВЭГЖАВЫН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Сонгуулийн уриа: "Эрдэнэт хотынхоо хөгжлийн төлөө"

Миний мөрийн хөтөлбөр нь Монгол улсын холбогдох хуулийн дагуу аливаа иргэн нь сонгох, сонгогдох эрхээ эдлэх хүрээнд Орхон аймгийн ИТХ-д бие даан нэр дэвшиж аймаг орон нутгийнхаа болон ард иргэдийнхээ сайн сайхан амьдралын төлөө тодорхой бодлого боловсруулж шийдвэр гаргах төвшинд ажиллах зорилгоор дэвшүүлэн тавьж байгаа зорилт юм.

Орхон аймаг Эрдэнэт хотын ард иргэд байгалийн баялагтаа эзэн нь байх, түүнээс олж буй орлого нь ард иргэдэд тэгж хүртээмжтэй байж. ажил амьдрал нь орлогтой болж өсөж дэвжихийг гол зорилгоо болгож байна.

Мөрийн хөтөлбөрт 5-н зорилт дэвшүүдэж байна.

### Нэг. Ажлын байр

- 1.1. Эрдэнэт үйлдвэр болон зэс боловсруулах үйлдвэрүүдийг түшиглэж импортыг орлох ажил үйлчилгээ бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг дунд аж ахуй нэгжүүдийг бодлогоор дэмжин ажиллана. Ингэснээр тодорхой хэмжээний ажлын байр бий болж ажилгүйдэл багасна.
- 1.2. ЖДҮ-ийг дэмжих сан. ХЭДС-ийн зээлийг ил тод нээлттэй иргэд хүртдэг болох. улмаар жижиг үйлдвэрлэл, үйлчилгээтэй болоход дэмжих

### Хоёр. Дэд бүтэц


- 2.1. Гэр хорооллын инженерийн шугам, дэд бүтэц ойр багуудад цэвэр, бохир, халаалтын асуудлыг шийдвэрэх тал дээр тооцоо судалгаа хийлгэж, дэмжиж ажиллана.
- 2.2. Хотын төвийн болон гэр хорооллын авто болон явган замыг сайжруулах, нэмэгдүүлэх бодлого барина.

### Гурав. Агаарын бохирдол

- 3.1. Эрдэнэт хотын агаарын бохирдолыг арилгах чиглэлээр санаачлагатай ажиллаж сайжруулсан түлш хэрэглэх зохицуулалтыг дэмжинэ.
- 3.2. Эрдэнэт үйлдвэрийн Хаягдлын аж ахуйн цагаан тоосыг арилгах тал дээр Эрдэнэт үйлдвэртэй хамтарч ажиллана. Ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.

### Дөрөв. Нийгмийн салбар

- 4.1. Сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх тал дээр анхаарна.
- 4.2. Эрүүл мэнд, эмнэлэгийн үйлчилгээг сайжруулахад бодлогоор дэмжлэг үзүүлнэ.
- 4.3. Өндөр, настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дэмжлэг үзүүлэх асуудалд анхаарч ажиллана.



**Тав: Төрийн үйлчилгээ**

5.1. Аймаг,сум,багаас иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээг хүртээмжтэй болгоход анхаарна.

5.2. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт оруулж, ил тод нээлттэй байх бодлогыг дэмжинэ.

Боловсруулсан :



С.Цэвэгжав

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Уурхайчин баг 3-45-24 тоот

Утас 99111578

